



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 24

Арвайхээр

Арвайхээр хотын ногоон байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “д” дэх, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх сумын ИТХурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Арвайхээр сумын бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх талаар баримтлах бодлого”-ийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Малчид, мал бүхий иргэд Арвайхээр хотын ногоон байгууламжинд малаа оруулж, тарьсан мод зүлэг идүүлж сүйтгэсэн тохиолдолд бод мал тутамд 10.000 /Арван мянга/ төгрөг, бог мал болон бусад тэжээвэр амьтад тус бүр 5000 /Таван мянга/ төгрөгөөр тооцон эзэнд нь нөхөн төлбөр ногдуулсугай.

2. Энэхүү тогтоолыг мөрдүүлж хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Засаг дарга бөгөөд хотын Захирагч /О.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гаргасантай холбогдуулан сумын ИТХурлын Тэргүүлэгчдийн “Арвайхээр хотын ногоон байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 49 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.АМАРТҮВШИН